

## **НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Цагаан сар бол байгаль дэлхий, цаг улирлаа танин мэдсэн өвөг дээдсийн мэдлэг ухаан, эдийн болоод оюуны соёл, ёс заншлын олон зүйлсийн цогцолбор чуулбар, мэндлэх, хүндлэх, талархах, бэлгэдэх ёсыг ёслон гүйцэтгэдэг Монгол хүний дархлаа, даяаршлын давлагааг сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлж, улс үндэстэн оршин тогтнох баталгаа болж байдаг Монгол үндэстний үнэт өв юм. Түүнчлэн залуу үе нь ахмад настнуудаа зорин очиж золгон хүндэлдэг баяр тул улс даяар авто замын хөдөлгөөн хамгийн ихээр идэвхжин нэмэгддэг онцлогтой. Уламжлал ёсоор Цагаан сарын битүүний өдөр буюу билгийн тооллын өвлийн адаг сарын сүүлийн өдөр болох 30-нд Цагаан сарын баярын бэлтгэл ажлыг хийхээс гадна тодорхой ёс заншлыг үйлддэг уламжлалтай. Гэтэл битүүний өдөр ажлын өдөр байдаг тул иргэд ёс дэгээ гүйцээх, сар шинэдээ бэлтгэх, нутаг орондоо зорчин ахмад настнууддаа золгох энэ бүх үйл хэрэгт хүндрэл бэрхшээл тулгардаг. Тиймээс Цагаан сарын баярын онцлог болон олон нийт, иргэдийн саналыг харгалзан үзээд Цагаан сарын өмнөх “битүүн”-ий өдрийг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”-д нэмэлтээр оруулахаар тус хуулийн төслийг бэлтгэв.

Монгол Улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа - 2050 баримт бичиг зэрэг хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний актуудаас харвал “Цагаан сар” нь Монгол түмний уламжлан авч үлдэх өв соёл гарцаагүй мөн бөгөөд Монгол Улс өв соёлоо хадгалан хамгаалах зорилго тавин боловсруулсан хөгжлийн бодлогын зорилтдоо хүрэхийн тулд энэ баярыг өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлэх, тэгэхдээ уламжлагдан ирсэн соёл, бэлгэдэлт ёс, зан үйлийг бүрэн гүйцээх боломжтой байх нь чухал юм.

Цагаан сарын баяртай холбоотойгоор замын хөдөлгөөний ачаалал ихсэж, улмаар цөөн хоногийн буюу үндсэн 3 хоногийн амралт таарах тусам зам тээврийн осол нэмэгдэж, амралтын хугацаа урт байх тусам буюу бямба, ням гарагт үргэлжлэн амрах эсвэл Засгийн газрыг тогтоол гарч ажил амралтын зохицуулалт хийгдсэн жилүүдэд зам тээврийн осол хэд дахин буурсан үзүүлэлттэй байгааг судалгаанд дүгнэсэн.

Мөн богино хугацаанд буюу 30 минутын хугацаанд цуглуулсан анкетын судалгаанд 115 иргэн хамрагдаж 110 хүн буюу 95,7 хувь нь битүүний өдөр амардаг байхыг дэмжсэн байна. Тухайн судалгаанд оролцогчдын 70 буюу 61,4 хувь нь битүүний өдөр ажлаасаа чөлөө авдаг хэмээн хариулсан байна.

Соёл судлаач, соёлын мэргэжилтнүүдийн хувьд “битүүний ёсон” буюу битүүний өдөр үйлдэх зан заншил, өв соёлын агуулга нь Цагаан сарын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болдог тул хамтад нь баярын өдөрт тооцож амардаг байх нь чухал хэмээх саналыг тэмдэглэжээ.

Эдгээр нөхцөл байдлыг үндэслэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дэх хэсэгт нэмэлт оруулж, Цагаан сар: билгийн тооллын **битүүн**, хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3 хэмээн өөрчлөхөөр хуулийн төслийг боловсрууллаа.